

ДАЯАРШИЛ УЛС ОРНУУДЫН БҮРЭН ЭРХИЙГ ХӨНДӨЖ БУЙГ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ОНОЛД ТУСГАСАН НЬ

Т.Төмөрхүлэг¹

Дэлхийн эдийн засаг нэгэн ерөнхий суурьтай болж буй нь улам бүр мэдэгдэх болов. Нийтийг хамарсан санхүүгийн тогтолцоо, нэгдмэл мэдээллийн орон зай, улс дамнасан үйлдвэрлэл, дэлхийн худалдааны сүлжээ бүрэлдэн бий болж байгаа нь үндэстэн улсуудын хил хязгаарыг арилгаж төрийн бүрэн эрхт байдлыг нь хувьсгах үр дагавар араасаа дагуулж байна. Дэлхий ертөнцөд үндсэн өөрчлөлт гарч буйн нэг жишээ гэвэл улс төрийн бодлого эдийн засагжих үйл явцаар харагдаж байна.

Энэ бүхэн үндэсний ашиг сонирхлын утга агуулгад илэрхий нөлөө үзүүлэхгүй байж чадахгүй. Энэ нөлөөллийн шинж чанар ямар вэ? Уг асуудлаар нэгдсэн ойлголт байдаггүй.

Олон улсын харилцааны онолыг судалдаг нэг хэсэг эрдэмтэн үзэхдээ зарчмын үүднээс ер шинэ зүйл тохиолдоогүй байна гэдэг. Тэдний бичиж байгаагаар, улс орон олон улсын харилцааны гол этгээд хэвээрээ л байна, Фукидидийн үеэс өөрчлөгдсөн юм алга, гагцхүү улс орнууд яаж ийгээд тэсвэрлэн үлдэж хөгжих шаардлагатай гэж тэд үздэг.

Дэлхий ертөнц төвөгтэй болж даяарыг хамарсан шинэ дуудлага гарч ирсэн нь хүн төрөлхтнийг эв санааны нэгдэлд хүргэхгүй, харин улс хоорондын зөрчлийг улам хурцатгана. Дэлхийн ашигт малтмалын нөөц дундарч байгаа нь нарийн арга хэрэгсэл, технологи хэрэглэн түүнд нэвтрэн орох боломж хайсан тэмцэл болж хувирав. Энэ тэмцэлд янз янзын орнуудын үндэсний ашиг сонирхол мөргөлдөж байгаа юм. Мөргөлдөөний шалтгаан нь дэлхийн борлуулах зах зээлийг дахин хуваарилах гэсэн үйл явц бөгөөд энэ нь зэвсэглэлээр хөөцөлдөх, цэрэг-улс төрийн холбоод эвслийн ужигшсан бодлогыг араасаа дагуулж байна. "Амин чухал ашиг сонирхол", "нөлөөний бүс нутаг", "төрийн бүрэн эрхийн зарчим" гэсэн ойлголт даяаршлын үеийн дэлхийн бодлогын мөн чанарыг тусгасан гол ойлголт хэвээрээ байна гэж тэд үзэж байна.

Нөгөө хэсэг судлаачид нь бол "дэлхийн бодлогын шинэ субъектүүд үндэстэн- улсын байрыг эзлэх болж байгаа" тул үндэсний эрх ашгийн агуулга нь бүрэн арчигдаж байна гэж ярьдаг. Тэдний үзэж байгаагаар, даяаршил үндэсний ашиг сонирхолд орон зай үлдээхгүй, тэрийг дэлхийн иргэний нийгмийн ашиг сонирхлоор сольж байгаа юм. Энэ ашиг сонирхлын үндсэн зүйл нь эдүгээ хүртэл улс орнуудын, ялангуяа улс төрийн эзэрхэг дэглэмүүдийн нухчин дарсаар ирсэн бие хүний эрх, эрх чөлөөг хангах явдал юм гэдэг. Үүнд уг үзэл бодлыг баримтлагчдын зарим нь үндэсний ашиг сонирхол, төрийн ашиг сонирхол

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш, Ph.D

хоёрыг “хагацуулан салгаж байна”, тэр ч байтугай “бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдалтай зууралдах бодлого” нь алс хэтдээ явцгүй хэмээн ярьж үндэсний эрх ашгийн тулд төрийн эрх ашгийн нэг хэсэг хувийг золиослохыг санал болгож байгаа юм. Гэвч бодит байдал илүү ярвигтай юм байна. Даяаршлын нөлөөгөөр улс орнуудын засаг төрийн байгууламж сүрхий доргиж байгаа нь үнэн юм. Олон улсын харилцаанд шинээр оролцогч субъектүүд улс орнуудын төрийн бүрэн эрхийн уламжлалт тэргүүлэх чиглэлийг бусниулж байна. Зарим судлаач, үндэсний засаг төр үнэ цэнээ алдаж байна гэдгийг тодотгохын тулд “тухайлсан газар нутаггүй болох”, “газар нутгийн төгсгөл” гэх зэргээр ярих болсон байна.

Улс орнууд “дээрээс”, “доороос”, “гаднаас” гэсэн гурван дарамт шахалтад өртдөг болсон байна.

Улс орнуудын онцгой эрхэд нь улам бүр хутгалдан орох болсон дээгүүр орших байгууллагуудын нөлөөгөөр улс орны төрийн бүрэн эрх мэдэл “дээрээсээ” хумигдах үзэгдэл гардаг. Үүнд, НҮБ-ын ивээлээр дэлхийн янз бүрийн хэсэгт болдог энх тайвныг тогтоох байлдааны ажиллагаа, тухайлбал, 1991 оны “Булангийн (Персийн булангийн) дайн”, 1992-1995 онд “Югославын дотоодын мөргөлдөөнийг олон улсын шинж чанартай болгосон явдал”, 1992-1993 онд Сомалид “Найдвар дахин төрүүлэх дайн” хийсэн зэргийг бид мэднэ. 1999 онд НҮБ-ын зөвшөөрөлгүйгээр олон улсын эрхзүйн хэм хэмжээг зөрчин Югославид “хүмүүнлэг давшилт” гэгчийг хийсэн.

Түүнчлэн улс орнуудад “тоглоомын дүрэм”-ээ тулгадаг Олон улсын валютын сангийн үйл ажиллагааг үүн дээр нэмэн дурдаж болох юм. Дэлхийн худалдааны байгууллагын хүрээнд улс орнууд зөвхөн бие биетэйгээ төдийгүй дотоодын дарамт үзүүлэх хэсэг (групп) хийгээд нам, иргэний нийгэмлэгүүдтэйгээ хэлэлцээ хийх ёстой болдог. Түүнээс гадна улс орнууд бүрэн эрхээ сайн дураараа хязгаарлах үзэгдэл ч гарч байна. Энд Европын Холбоог хэлж байгаа юм.

“Доороосоо” улсын бүрэн эрх, улсын дотоодын бүтэц, иргэний нийгэмлэгүүдийн зүгээс учруулж буй дарамт шахалтад өртөж байна. Энд холбооны улсууд, автономит улсууд эрх хэмжээндээ өөрийн гэсэн гадаад бодлого явуулдаг гэдгийг онцолж авч үзэх ёстой юм. Манай Монголд бол ийм үзэгдэл байхгүй. Харин яваандаа зах хязгаарын аймгууд хил залгаа гадаад улсуудтай харьцангуй бие даасан харилцаанд орж болох юм. Тэгвэл улсын бүрэн эрхийн зарим нэг хувийг завших явдал гарч болзошгүй. Яагаад иймэрхүү зан авир гарч ирдэг вэ гэдгийг эрхбиш судлууштай юм. Үүнд, Үндсэн хуулийн тогтолцоо төгс төгөлдөр болоогүй явдал, өөрөөр хэлбэл, төв засгийн газар нь орон нутгийнхаа бодлогыг хавчих юмуу дарах юм бол “төвөөс зугтаах хандлага” бий болдог байна. Нөгөөтэйгүүр улс доторх дэд оролцон тоглогчид улсаас санхүүгийн хувьд хамааралгүй болохыг эрмэлздэг байна. Энд анхаарах ёстой нэг зүйл гэвэл, даяаршлын эрин үед засаг захиргааны эрх мэдлийг орон нутагт өргөтгөх зайлшгүй шаардлага гарч ирж байна.

“Гадна талаас” улсын бүрэн эрх мэдэлд засгийн газрын бус групп, байгууллагууд нөлөөлөх болсон нь үнэн юм. Улс дамнасан корпорац, фирм, банк, аж үйлдвэрийн нэгтгэлүүдийн шахалтаар улсын онц эрх алдагдаж байгаа тал бий. Үндэсний эдийн засгийн олон салбар дахь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тухайн улсын засгийн газрын гадуур гүйцэтгэгдэх болжээ. Өнөөгийн дэлхий ертөнцөд баялгийг хуваарлах нь тухайн улсын

төрийн бодлогоос илүүтэй Олон улсын валютын сан, Дэлхийн банкны гүйцэтгэж буй мөнгөний шилжүүлгээс голчлон шалтгаалах хандлагатай болжээ. Олон улсын валютын сан Монгол улсын 2012 оны төсвийг хэлэлцэхэд засаг захиргааны зардлыг танахыг шаардаж ёсоор болгуулсан нь инфляцийг тодорхой хэмжээнд барихад зөв зүйтэй зөвлөгөө боловч улсын бүрэн эрхийг туйлын утгаар нь авч ярихаар дарамт шахалт л болж байгаа хэрэг шүү дээ. Улс дамнасан корпорацууд татварын салбарт улам бүр үүрэг гүйцэтгэх болж байна. Хувийн фирмүүд болон ҮДК (Үндэстэн дамнасан корпорацууд) улс орнуудын нийгмийн засаглал, ажиллах хүчний хуваарилалт, ажлын хөлс, хөдөлмөрийн нөхцөл зэрэг салбарт явуулдаг бодлогыг "булааж авах" болжээ. Нэгэн үгээр хэлэхэд, энэ бүхэн тухайн улсын хууль тогтоомжоор зохицуулагдахаасаа илүүтэй мөнөөх фирмүүдийн дотоод дүрэм журмаар шийдэгдэх болсон байна. Энэ бол бидэнд дохио сургамж болох учиртай юм. Монголд ажиллаж буй гадаадын уул уурхайн нэг компани 50-иад монгол ажилчинг ажлаас халсныг Үйлдвэрчний Холбоо Монголын хуулийг уландаа гишгэсэн хэрэг гэж мэдээллийн хэрэгслээр саяхан мэдэгдсэн. Энэ юуг харуулж байна вэ гэвэл улс орны нийгмийн бодлогыг хэрэгжүүлэхэд ҮДК-ууд садаа учруулдгийн зах зүх харагдаж л байгаа хэрэг юм. Энэ мэтчилэн бидний урьдчилан олж хараагүй, санаандгүй гэмээр олон олон асуудал, ялангуяа эрхзүйн хүрээнд цаашдаа ч гарч ирэх төлөвтэй.

Улсын тухайд нүүрэлж буй энэ хямрал ялангуяа эдийн засгийн хувьд дорой, улс төрийн хувьд тогтворгүй дунд зэргийн болон багавтар орнуудад бүр ч халгаатай тусаж байгаа юм. Үнэхээр даяаршил бүхий л улс орныг өөртөө татан оруулахдаа тэдгээрийн тусгаар тогтнол, улс төрийн дэглэмийн хэв шинж, эдийн засгийн хөгжлийн түвшинг хайхрахгүй байгаа юм.

Олон улсын харилцаанд шинээр оролцон тоглогчид улс орнуудын аюулгүй байдлын бодлого хийгээд эдийн засаг, харилцаа холбооны салбар дахь үүрэг ролийг нь бусниулахдаа улсын бүрэн эрх мэдлийн хамгийн эрхэм дээд гэгдэх "хүч хэрэглэх" онц эрхийг нь ч хөндөж байгаа юм.

Тийн авч шинэ субъектүүд улс орнуудыг олон улсын харилцаанаас шахан гаргаж байгаа тухай, улсын бүрэн эрх алга болж байгаа тухай, даяаршил урагшлахын хирээр үндэсний эрх ашгийн ач холбогдол алга болж байгаа тухай сэдэв дэвшүүлэх нь эртэдсэн хэрэг гэж нэлээд олон эрдэмтэн судлаач үзэж байна.

Ингэхэд шинэ субъектүүд улс орнуудыг олон улсын бодлогоос шахан гаргаж байгаа явдал үгүй, харин өрсөлдөөнөөр ч, хамтын ажиллагаагаар ч тэдэнтэй төвөгтэйхөн хамтын ажиллагаанд ордог гэж үзэх нь үнэнтэй илүү нийцнэ. Олон улсын харилцаанд шинээр оролцон тоглогчдын өрсөлдөөн нь тодорхой хэмжээний хамтын ажиллагаатай хосолж явдаг юм. Хясал хясаантай нөхцөл байдалд чухамдаа улс орнууд л улс бус оролцон тоглогчдод хүсэл эрмэлзлээ тулгаж чаддаг гэдгийг бид бодолцох ёстой юм. Өнөөгийн нөхцөлд ядуу дорой орнууд хүртэл олон үндэстний корпорацийг улсын болгож чадна. Өнгөрөгч оны 8 дугаар сард Гвиней улсын хууль тогтоогчид уул уурхайн шинэ хууль гарган гаалийн татвараа 8%-иар нэмэгдүүлсэн нь тус улсын төмрийн хүдрийн орд газарт 10 тэрбум ам. долларын хөрөнгө оруулсан Рио Тинто компанийг ихээхэн сандаргасан байх жишээтэй.

Түүнээс гадна олон улсын харилцаанд улсын бүрэн эрх мэдэл хэзээ ч туйлын хэмжигдэхүүн байгаагүй, байж ч болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй юм. Олон улсын эрх зүй бол улс орны өөртөө сайн дураараа үүрэг хүлээдэг тогтолцоо мөний хувьд үйл ажиллагааных нь эрх чөлөөг хязгааралдгаараа улс төрийн бие даасан байдлыг нь хумьдаг юм. Бүрэн эрхийн тухай ойлголтыг эдүгээ "харилцан хамаарал" гэдэг ухагдахуунтай диалектик харьцаанд авч үзэх л юм бол утга учир нь тодроод гарч ирнэ. Бүрэн эрхээ хамгаална гэдэг нь харилцан хамаарлын дарамт учирлаа ч гэсэн, эсвэл үүнийг эргүүлж ашиглаад зорьсондоо хүрэхийн төлөө цуцалтгүй зүтгэж чадахыг хэлж байгаа юм.

Үндэсний үзэл давамгайлах нь үндэстэн улс сульдаж буйн тэмдэг гэсэн үзэл суртлын шинж чанартай нэг баримтлал яваад байгаа юм. Гэвч энэ нотолгоог шинээр тусгаар тогтносон олон орон дэлхийн тавцанд гарч ирсэнтэй уялдуулан авч үзэх юм бол эргэлзээтэй гэж хэлэх үндэслэлтэй. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эх оронч - үндэсний үзлийг өргөн дээдлэх санаа суулгасныг энд дурдаж болох юм. Товчоор өгүүлэхэд эдүгээ үед Улсын бүрэн эрхийн уламжлалт үүрэг роль харьцангуй унах хандлага ажиглагдахын сацуу бүрэн эрхийнхээ шинж тэмдгийг идэвхтэй хамгаалдаг тусгаар тогтносон шинэ залуу улсууд бүрэлдэн тогтох эерэг хандлага ч байгааг тэмдэглэвэл зохино.

1980-аад оны эцсээс Улсын бүрэн эрхийн асуудлаар явуулсан төрөл бүрийн шинжилгээ судалгаагаар бие биеэ харилцан нөхөх хоёр үндсэн дүгнэлт гарч ирсэн байна. Эхний дүгнэлт нь юу вэ гэвэл, хэдийвээр ҮДК-ууд маш олон зах зээлд нэвтэрч зүсэн бүрийн үйлдвэрлэл рүү орсныхоо хирээр ашиг хонжоо олохыг хичээвч өөрийн үйлдэл стратегиа дэлхийн хэмжээнд хэрэгжүүлнэ гэж тооцоолж үнэхээр даяар удирдлагын багтай болсон глобал үйлдвэр хуруу дарам цөөхөн байгаа юм. Уг судалгааны хоёр дахь үр дүн нь үйл явцыг нийтэд нь хамарч байгаа юм. Даяаршил хүчээ авч байна. Гэхдээ үндэсний хийгээд бүс нутгийн орон зай ач холбогдлоо алдаагүй, харин улсын засаг төр уг үйл явцын өмнө хүчгүйдэж байна гэсэн дүгнэлт гаргажээ. Үндэсний засгийн газрууд, тухайлбал Монгол улс хэдийвээр либерал гэсэн утгад нийцүүлэн шинэтгэл хийлээ ч эдийн засаг, нийгмийн бодлогын хүрээнд сонголт хийх боломжоо алдаагүй. Францын судлаач Моро-Дефарж бичихдээ: "Улс орон эрх мэдэл, эв нэгдлийн хариуцлагаа алдчихаагүй байна. Тэгэхдээ, нээлттэй хил хязгаартайгаар... хохирол амсахгүй юмсан гэсэн бодолтойгоор тэрийгээ хэрэгжүүлж байна" гэжээ. Францын "Politique Etrangere" сэтгүүлийн 1997 оны нэг дугаарт бичсэн нь: Даяарчлагдах үйл явцыг задлан шинжлэхдээ гаргаж буй түгээмэл алдааны нэг нь "Улс орон үүрэг ролио алдаж байна, бүрэн эрхийн тухай ойлголт утга чанараа гээж байна" гэсэн дүгнэлтээс гараагаа эхэлдэг явдал юм" гэжээ.

Даяаршлын тухай эргэцүүлэхдээ, ядахдаа хоорондоо нягт холбоо бүхий хоёр үйл явцыг умартаж болохгүй. Нэгдүгээрт, түүний (даяаршлын) диалектик эсрэг тэсрэг чанар, бүс нутагчлалын тухай юм. Үүнтэй холбогдуулж бүс нутгийн интеграцийн байгууллагууд (Европын Холбоо, Умард Америкийн Чөлөөт худалдааны нийгэмлэг, Өмнөдийн нийтийн зах зээл, АСЕАН) даяаршлын шинж тэмдгийг илэрхийлэхийн сацуу даяаршлын эсрэг хандлага харуулдгийг дурдаж болно. Жишээлбэл, гуравдагч улсуудаас орж ирж буй нүүдлийн хөдөлгөөнийг хязгаарлах, олон улсын худалдааны салбарт зах зээлээ хамгаалах хориг саад тавихтай холбогдсон хатуухан шийдвэрийг чухамдаа Европын Холбоо л

гарагадаг билээ.

Улсын бүрэн эрх, үндэсний ашиг сонирхол "мөхөхийн" шалтгааныг интеграцын үйл явц, олон улсын байгууллагуудтай холбож тайлбарлах нь явуургүй. Судлаач мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар "бүс нутгийн интеграц чухамдаа, дотооддоо адил төстэй асуудлуудтай тулгарсан орнуудын хоорондын өрсөлдөөнөөр интеграцид нэгдэхээс өөр арга замгүйд хүрсэн юм. Энэ үүднээс зохих шийдвэр хамтдаа боловсруулах шаардлага аяндаа гарч ирсэн гэжээ.

Хоёрдугаарт, даяаршлын эсрэг хандлага, өөрөөр хэлбэл даяаршлыг задлах, дэлхийн улс төрийн бодлогод уламжлалт геополитикийн хүчин зүйлийг хэвээр байлгах гэсэн хандлага байгааг мартаж болохгүй. Ийм хандлага хэдийгээр хоёрдахь шинж чанартай боловч түүний үр нөлөөний ач холбогдлыг үндэсний эрх ашгийн үүднээс дутуу үнэлж болохгүй. Хүйтэн дайны дараа, ялангуяа тогтвортой бүс бүс нутгуудад улс орнуудын үүрэг роль суларсан нь эзэн биегүй зах зээлийн нөлөө мөнөөс гадна АНУ үзэл суртлын өрсөлдөгч (хуучин ЗХУ) -өө унасны дараа нэг туйлт ертөнцийн бодлогоо хүлээлгэх гэж махруу хичээж байгаатай бас учир холбогдоно. Францын зарим эрдэмтний үзэж байгаагаар, хүйтэн дайны дараагаар Европ, Азид дэлгэрсэн бүс нутагжих үйл явцын нэг зорилт нь жолоогүй либералчлалаас зайлсхийх, улмаар орчин үеийн цорын ганц хэт их гүрэн болох АНУ-ын жанжлах бодлогод эсэргүүцэл үзүүлэх гэсэн эрмэлзэл юм гэжээ. (Sachwald, F. La mondialisation comme facteur de l'integration regionale //Politique etrangere, etc 1997. № 2)

Ийнхүү үндэстэн улс, түүний бүрэн эрх, ашиг сонирхол нь ач холбогдлоо хэвээр хадгалсаар байна. Гэвч даяаршил үндэсний эрх ашигт ямар ч өөрчлөлт оруулаагүй гэсэн үг биш. Чухамхүү даяаршлын нөлөөгөөр үндэсний эрх ашгийн агуулга, чиглэлд мэдэгдэхүйц хувиралт гарсан. Үүнд, нэг талаар даяаршлын нээгдүүлж байгаа боломжид дасан зохицох, нөгөөтэйгүүр, даяаршлын улмаас үндэсний хөгжилд учруулах хохирлыг гэтлэн давах замаар түүний давуу талыг ашиглах шаардалгатай уялдсан тэргүүлэх чиглэл шинээр гарч ирж байна.

Улс орноо дэлхийн эдийн засгийн хөгжлийн гольдролд багтаах нь үндэсний эрх ашгийн нэг чухаг тэргүүлэх чиглэл болж байна. Учир нь даяаршлын үйл явцаар нэг ч улс орон дэлхийн эдийн засагт багтан орохгүйгээр эдийн засгийнхаа хөгжлийг олигтой түргэтгэж чадахгүй, ард олныхоо амьжиргааг мэдэгдэхүйцээр өөд татаж дийлэхгүй нь нэгэнт тодорхой болжээ. Үндэсний эрх ашгийн бүтцэд мэдээлэл холбоо, тээврийн хамгийн орчин үеийн нийцшилтэй тохирох тэргүүний технологийг эзэмших эрмэлзэл тэргүүн байранд явж байна. Цэрэг дайны хүчин зүйл болон үүнтэй холбогдох стратеги (хүчний тэнцвэр, холбоотны гэрээ байгуулах г.м) үндэсний эрх ашгийн шатлалд тэргүүн байрнаас ар тийшээ шилжиж буй. Гэхдээ арай ч хамгийн сүүлд нь биш ээ. Үнэхээр үндэстэн улсын амьд үлдэх эсэх нь уламжлалт цэрэг дайны аюул заналыг сөрөн зогсох чадвараас хамаарахаасаа илүүтэй эдийн засаг, технологи, экологи, хүн ам зүйн хийгээд мэдээллийн шинж чанартай шинэ дуудлагад нийцсэн хариу олох боломжоос шалтгаалах болжээ.

2010 оны 7 дугаар сард шинээр батлагдсан Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд сая өгүүлсэн тэргүүлэх чиглэлүүд ерөнхийдөө шингэж орсон гэж бид ойлгож байгаа.

Даяаршил нь "сул" буюу "буурай улс" хэмээх нэр томъёогоор илэрхийлэгдэх эрч хүчийн тухай ойлголтыг буй болгосон байна. Энэ нь одоогийн шатанд шилжилтийн үеийн эдийн засагтай, улс төрийн хувьд тогтворгүй Дорнын сул хөгжилтэй орнуудыг хөндөж буй боловч ерөнхийдөө бүхий л улс оронд хамаарах юм. Үүнтэй холбогдуулан орчин үеийн улсуудын үндэсний эрх ашгийн бүтцэд засаг төрийнхөө байгууламжийг бататган чийрэгжүүлэх явдал чухар байр суурь эзэлнэ.

Үнэхээр "үндэсний (нийгмийн) эрх ашиг, "засаг төрийн" эрх ашиг нь хоорондоо үгүйсгэлцэх бус, харин ч бие биеийгээ нөхдөг байна. Иймд энэ хоёр эрх ашгийн аль нэгийг хохироох юмуу "найр тавьж өгөх" аваас хоёрдахь нь суларч доройтно гэж олон судлаач үзэж байна. Улс орон газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлаас татгалзана гэдэг бол тэр улс суларч доройтно гэсэн үг. Сульдсан улс ард олныхоо амьжиргааны түвшин, аюулгүй байдал, нийгэм болоод хүний эрх чөлөөний тухайд даяаршлаар олдож буй боломжийг ашиглах хийгээд даяаршлын сөрөг үр дагаврыг хазаарлан зогсоохтой уялдсан дуудлагад зохих ёсоор хариу өгч чадахгүй. (Авдеева, Стукало, 2000, стр.51)

Гадаадын болон дотоодын аюул заналаас үндэсний эрх ашгаа, нэгэн үгээр хэлэхэд үндэсний аюулгүй байдлаа хамгаалах нь олон улсын харилцаанд чухал байр суурь эзэлсэн хэвээр байна.